



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 09 дугаар
сарын 25-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.7, 28 дугаар зүйлийн 28.8.2, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг соёрхон батлах тухай хууль”, Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан “Санхүүжилтийн хэлэлцээр”-ийг тус тус үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөрийн зах зээлийн дэмжих туршилтын хөтөлбөр”-т хавсралтад заасан нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. “Хөдөлмөрийн зах зээлийн дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн удирдамжийг шинэчилж, мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т, хэрэгжилтийг хангаж, тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  С.ЧИНЗОРИГ



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний
зөвлөлийн нарийн бичгийн дарга  Д.Хадхүү



Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт

Тав. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт

5.2.1. “Нийслэлийн төвийн 6 дүүрэгт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Нийслэлийн алслагдсан 3 дүүрэг, 21 аймаг (цаашид орон нутаг гэх)-ын хувьд, зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэл, суралцах иргэний тоог тусгасан ерөнхий саналаа орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн байгууллага нь тухайн орон нутгийн ажлын байрны бодит эрэлтэд нийцүүлэн ажил олгогчид, мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагатай хамтран боловсруулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлнэ. Сургалт зохион байгуулах санал нь шаардлага хангасан болохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас үнэлж, баталгаажуулсны дагуу орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалт зохион байгуулах дэлгэрэнгүй төсөл, сургалтын хөтөлбөрөө Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж, батлуулсны үндсэн дээр сургалт зохион байгуулна.” гэж,

5.2.2. “Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг Улаанбаатар хот, нийслэлийн алслагдсан 3 дүүрэг, 21 аймгийн төвд жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна¹.” гэж,

5.2.3. “Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг Улаанбаатар хотод² зохион байгуулах сургалтын байгууллагыг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн³, нээлттэй тендерээр, зохих шалгуурын дагуу сонгон шалгаруулж, үр дүнд суурилсан санхүүжилтийн⁴ гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.” гэж,

5.2.4. “Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас зохион байгуулах сонгон шалгаруулалтад мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий⁵ шаардлага хангасан төрийн болон хувийн хэвшлийн мэргэжлийн сургалтын болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага оролцоно.” гэж,

¹ Сургалтыг сумдад зохион байгуулахгүй.

² Төвийн 6 дүүрэг хамаарна.

³ “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
⁴ Үр дүнд суурилсан санхүүжилт гэж сургалтын үр дүнгийн зорилтот түвшний биелэлтийг харгалзан санхүүжилтийн эцсийн төлбөрийг тооцож олгохыг хэлнэ.

⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/257, А/582 тоот тушаалаар баталсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага тогтоох журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А104 тушаалаар баталсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, заавар”-ын дагуу эрх авсан сургалтын байгууллага байна.

5.2.6. “Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулсан шийдвэр, үндэслэлийг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.

5.2.7. “Орон нутагт хэрэгжүүлэх сургалт нь хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бүрэлдэхүүн, агуулга, тавигдах шаардлагатай бүрэн нийцсэн байх бөгөөд тухайн орон нутгийн ажлын байрны бодит эрэлт дээр тулгуурлаж, суралцагч нь сургалтын дараа шууд ажлын байртай болсон байхаар төлөвлөж, зохион байгуулна.” гэж,

5.3.6. “Сумаас аймагт ирж суралцаж байгаа суралцагчид нэг удаагийн ирэх, очих унааны зардлыг нийтийн тээврийн жишиг зардлаар тооцож олгоно.” гэж тус тус нэмсүгэй.

---oOo---